



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Налайх дүүргийн "Чандмань налайх"  
ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн  
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 73,468,400.0 /далан гурван сая дөрвөн зуун жаран найман мянга дөрвөн зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн "Чандмань налайх" ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 1,800,000.0 /нэг сая найман зуун мянган/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Налайх дүүргийн "Чандмань налайх" ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Налайх дүүргийн "Чандмань налайх" ОНӨААТҮГ (З.Болдбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000233 Тушаал 2021

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2021 оны .04 дугаар сарын 04 -ны  
өдрийн 04/04 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Бүртгэлд тусгах үнэ
1	Налайх дүүргийн "Чандмань налайх" ОНӨААТҮГ	Зил-130 АЦП 55-79 НАА	5,468,400.0	5,468,400.0	0.0	800,000.0
2		Исузу 68-51 УНВ	68,000,000.0	68,000,000.0	0.0	1,000,000.0
<b>Дүн</b>			<b>73,468,400.0</b>	<b>73,468,400.0</b>	0.0	<b>1,800,000.0</b>